

ХУВЬЦАА ХЭРХЭН ХУДАЛДАН АВАХ

“ХайБиОйл” ХК-ны хэвийн үйл ажиллагааг явуулахад шаардагдаж буй 388 сая төгрөгний санхүүжилтэнд зориулж 174 төгрөгний нэрлэсэн үнэтэй 2,234,268 ширхэг энгийн хувьцааг нэмж гаргаж байна.

Нэмж гаргаж буй энгийн хувьцааг доорхи байдлаар нийтэд санал болгож байна.

- “БиДиСек” ХК, “ЭмИТиЭф” ХХК-ийн хувьцаанд хөрвөх зээлийн гэрээний дагуу оруулсан нийт 289,520,300 төгрөгийн зээлийг нэг бүр нь 174 төгрөгийн үнэтэй 1,663,910 ширхэг хувьцаанд хөрвүүлэх
- Нийтэд нээлттэй худалдагдах 570,358 ширхэг энгийн хувьцааг нэг бүрийг нь 174 төгрөгөөр нийтэд худалдах

	Ажлын дараалал	Хугацаа
1	Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэр	2010 оны 8 сарын 25-ны 234 тоот тогтоол
2	Монголын хөрөнгийн биржийн шийдвэр гарах	Ажлын 30 хоног
3	Хувьцаа эзэмшигчид тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэгжүүлэх хугацаа	2010 оны 8 сарын 25-ны өдрөөс 2010 оны 10 сарын 6-ны өдрийг дуустал ажлын 30 хоног
4	МХБ-ээр дамжуулан олон нийтэд санал болгон арилжаа	Хувьцаа эзэмшигчид тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэгжүүлэх ажлын 30 хоногийн хугацаа дууссаны дараа

2009 оны 10 сарын 6-нд гаргасан тархалтаар буюу 2009 оны 11 сарын 17-ны ээлжит бус хурлын бүртгэх өдрөөр хувьцаа эзэмшиж байсан хувьцаа эзэмшигчид Компанийн тухай хуулийн 35.1.4 болон 39 дүгээр зүйлд заасны дагуу нэмж гаргаж буй энгийн хувьцаанаас өөрийн эзэмшиж буй хувьцааны 31,92 хувьтай тэнцүүлэн тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй.

- Хувьцаа эзэмшигчид тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэгжүүлэхдээ харьяа брокер, дилерийн компанидаа захиалга өгч, хувьцаа тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэгжүүлэх мэдэгдэл, хувьцааны үнийг төлсөн баримтын хамт “ХайБиОйл” ХК-д ирүүлнэ.
- Тэргүүн ээлжинд худалдан авах хувьцааны арилжаа хоёрдогч зах зээлийн арилжаанаас тусдаа зохион байгуулагдана.
- Хувьцаа эзэмшигчид тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэгжүүлэх талаар мэдэгдээгүй нөхцөлд тухайн хувьцааг хувьцаа эзэмшигч тэргүүн ээлжинд худалдан авах эрхээсээ татгалзсанд тооцож, хувьцааг МХБ-ээр нийтэд санал болгон худалдан борлуулна.
- Нэмэлт хувьцааны талаарх дэлгэрэнгүй мэдээг: Харилцагч нар өөрийн харьяа брокер, дилерийн компаниуд болон Хөрөнгө оруулалтын зөвлөх,

ХайБиОйл ХК – Нэмэлт санхүүжилт татах танилцуулга

Андеррайтер, Брокер, Дилерийн БиДиСек ХК-аас мөн www.bdsec.mn,
www.hboil.mn сайтуудаас авч болно.